

МОНГОЛ УЛСЫН УЛС ТӨРИЙН ГАДААД ХАРИЛЦАА

Нийгэм судлал 10-р анги

Багш Д.Уранцэцэг

III улирал.

Email: [D.Urantsetseg 55@gmail.com](mailto:D.Urantsetseg55@gmail.com)

Утас: 99291533

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

- Монгол Улсын улс төрийн гадаад харилцааны агуулга, чиглэл, хэлбэрийг жишээгээр тайлбарлаж, үнэлэлт өгөх
- Монголын улс төрийн гадаад харилцааны зорилго, чиглэл, хэлбэрийг амьдралын бодит жишээ, бүдүүвч, диаграмаар илэрхийлэх,
- Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал

ТУЛГУУР ОЙЛГОЛТ

Улс төрийн гадаад бодлого гэдэг нь үндэсний сонирхлыг тусгасан зорилгуудыг тодорхойлох, бусад улс, олон улсын байгууллагад нөлөөлөх замаар тэдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа юм.

Улс төр (Англи: Politics; Орос: Политика) гэдэг нь ард түмэн, иргэд, сонирхлын бүлгүүдийн шийдвэр гаргах үйл явц юм.


Иймд аливаа засаглалын харилцаа үйл ажиллагааны зөвхөн төрийн эрх мэдэлтэй холбогдох тэр хэсгийг улс төр гэж ойлгож болно. Төр улс 6000 жилийн өмнө үүссэн гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

УЛС ТӨРИЙН ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

Монгол Улсын улс төрийн гадаад харилцааны бодлогын зорилго нь тус улсын аюулгүй байдал, хөгжил дэвшлийг хангах таатай гадаад орчин бүрдүүлэх, дипломат болон консулын харилцаа хөгжүүлэх, нөлөө бүхий улсуудтай харилцааныхаа түвшинг дээшлүүлэх, олон улсын байгууллага дахь үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахад оршино.

ГАДААД БОДЛОГЫН ШИЙДВЭР ГАРГАХ ОНОЛ



УЛС ТӨРИЙН ГАДААД БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

14.1.ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх;

14.2. АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг Өрнө, Дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

4.4.Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх.

14.5.Хөгжиж байгаа улсуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллага, "77"-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах.

15.Улс төрийн гадаад харилцааны бодлогын чиглэлүүдийг харгалзан тус улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын байршлыг тогтоож, гадаад бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг сайжруулна.

Монгол Улс дэлхийн 181 оронтой
дипломат харилцаатай.

Гадаадын 31 оронд
Монгол Улсын Элчин
сайдын яам

Гадаадын 8 оронд 11
Ерөнхий Консулын
газрууд

5 Консулын төлөөлөгч

Өргөмжит консулууд
75 гадаад орнуудад

Монгол Улсын энгийн
паспорттай иргэд 19
оронд визгүй

Албан, дипломат
паспорттой иргэд 45
оронд визгүй

БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-1

Улс төрийн гадаад бодлогын загваруудын давуу болон сул талуудыг ялган бичнэ үү?

Онолын загварууд	Давуу тал	Сул тал	Сурагчийн өөрийн дүгнэлт
А загвар			
Б загвар			
В загвар			
Г загвар			

БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-2

Дараах сэдвүүдээс сонгож, 300-350 үгтэй эргэцүүлэмж бичээрэй

АНУ, Япон, Европын Холбоо зэрэг өрнө Дорнын улсуудтай түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх нь

Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж

ГЭРИЙН ДААЛГАВАР

1. Бие дааж хийх даалгавар 1,2 -г дэвтэртээ хийгээрэй.
2. Сурах бичгийн 135-137 хуудсыг сайн уншиж судлаарай.